



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/281

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 37 дугаар
цэцэрлэгийн данснаас барилга
байгууламж, нийтийн эзэмшлийн
эд хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 96 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/708 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-117/1552 дугаар дүгнэлтийн дагуу Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах, энэ тушаалын хавсралтад заасан 225,043,360 /хоёр зуун хорин таван сая дөчин гурван мянга гурван зуун жаран/ төгрөгийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэг /С.Сэлэнгэ/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэг /С.Сэлэнгэ/-т даалгасугай.

3. Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой материалыг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлсэн 9,761,640.0 /есөн сая долоон зуун жаран нэгэн мянга зургаан зуун дөчин/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхийг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 47. . дугаар сарын
31... өдрийн 4/28 дугаар тушаалын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ 2019.03.31/
1	Барилга	1963	ш	507.4	218,384,960	200,040,777	18,344,183
2	Бохирын шугам	1963	у/м	38.8	2,716,000	2,716,000	-
3	Цэвэр бохир усны шугам	1963	у/м	38.8	2,557,600	2,557,600	-
4	Мод	1963	ш	47	394,800	0.00	394,800
5	Тоглоомын талбай	1963	у/м	11	550,000	550,000	-
6	Хайс хашлага	1963	у/м	69.6	440,000	440,000	-
НИЙТ ДҮН					225,043,360	206,304,377	18,738,983